



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/437

Булган сум

Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай" IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хутаг-Өндөр, Бугат, Орхон сумын 20 га талбайд ойжуулалт нөхөн сэргээлтийн арчилгаа, хамгаалалт хийх ажлын гүйцэтгэгчээр "Хөвөнтөн ой" ХХК шалгарсан тул холбогдох хууль, тогтоомжийн дагуу 19,700,000 (арван есөн сая долоон зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Байгаль орчны газар (А.Гантөмөр)-т олгосугай.

2.Гэрээ байгуулах эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох хэлтэст тайлагнахыг Байгаль орчны газар (А.Гантөмөр), гэрээнд заасан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Хөвөнтөн ой" ХХК-ийн захирал (Ч.Оюун) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний "2024 онд хийгдсэн ойжуулалт, нөхөн сэргээлтийн арчилгаа, хамгаалалтын зардал 20 га (Хутаг-Өндөр, Бугат, Орхон сум)" төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Э.Эрдэнэжаргал)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

